



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/338

Улаанбаатар хот

Үнэмлэхийн загвар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үнэмлэхийн загварыг 1 дүгээр, хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үнэмлэхийн тодорхойлолтыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2.Хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үнэмлэхийг захиалж хийлгэхтэй холбоотой санхүүжилтийг холбогдох зардлаас гаргахыг Санхүү, аж ахуйн хэлтэс /Б.Өэлүн-Үжин/-т зөвшөөрсүгэй.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/, Хяналт шалгалтын газар /Б.Ганзориг/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

571002527

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны  
А/338 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



**Хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үнэмлэхийн загвар**

5296722 1115266216 ГСТ60 Нүүрэн тал	
Хяналтын улсын /ахлах/ байцаагч	
Дотор тал	Дотор тал
<p>Хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үнэмлэх</p> <div style="border: 1px solid black; width: 100px; height: 100px; margin: 10px auto; text-align: center;">Зураг</div> <p style="text-align: center;">Дугаар</p> <p>Хяналтын улсын /ахлах/ байцаагч .....овогтой .....Нь</p>	<p>Хяналтын улсын /ахлах/ байцаагч бол Монгол Улсын бүртгэлийн болон Зөрчлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих талаар хууль тогтоомжид заасан төрийн захиргааны хяналт, <b>шалгалтын талаарх бүрэн эрхийг эдэлж, хариуцлага хүлээлгэх</b> эрх бүхий албан тушаалтан мөн.</p> <p>Улсын байцаагчийн шийдвэрийг иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.</p> <p>Улсын байцаагч хяналт шалгалт хийх объектод саадгүй нэвтрэн орох эрхтэй.</p> <p style="text-align: center;">Дугаар</p> <p>Үнэмлэхийг бусдад шилжүүлэхийг хориглоно. Олгосон огноо: Ажиллах хугацаанд хүчинтэй.</p> <p style="text-align: center;"><b>УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ</b></p>

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021  
оны 4/238 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**ХЯНАЛТЫН УЛСЫН /АХЛАХ/ БАЙЦААГЧИЙН ҮНЭМЛЭХИЙН  
ТОДОРХОЙЛОЛТ**

Хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үнэмлэх нь 18x8см хэмжээтэй, голоороо 9см хэмжээгээр нугалах зориулалтын горимтой, цэнхэр өнгийн хавтастай байна.

**Нэг.Үнэмлэхийн нүүрэн тал**

1.1.Хавтасны нүүрэн талын дээд захаас 2см, зүүн баруун захаас 5см зайд Улсын бүртгэлийн байгууллагын бэлэгдэл /лого/-ийг байрлуулж, түүний гадна талаар “УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР, ХЯНАЛТ ШАЛГАЛТ” гэсэн бичвэрийг хагас тойрог хэлбэрээр байрлуулна.

1.2.Хавтасны доод захаас 1см, баруун зүүн захаас ижил зайд “УЛСЫН /АХЛАХ/ БАЙЦААГЧ” гэсэн бичвэрийг “Arial-12” үсгийн фонд, хэмжээгээр бичиж, голлон байрлуулна.

**Хоёр.Үнэмлэхийн дотор тал**

2.1.Үнэмлэхийн дотор тал 9см хэмжээгээр нугалах зориулалтын горимтой, дээд захаас 1см зайд “Хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үнэмлэх” гэсэн бичвэрийг “Arial-11” үсгийн фонд, хэмжээгээр бичнэ.

2.2.Үнэмлэхийн дотор талд зүүн захаас 3см зайд 3x4 хэмжээтэй зураг байрлуулах тэгш өнцөгт бүхий хэсэг байна.

2.3.Үнэмлэхийн дотор талд зүүн захаас 5см зайд “Хяналтын улсын” /ахлах/ байцаагч

.....овогтой

.....нь гэсэн бичвэрийг “Arial-11” үсгийн фонд, хэмжээгээр бичнэ.

2.4.Үнэмлэхийн дотор баруун талд дээд захаас 1см зайд “Хяналтын улсын /ахлах/ байцаагч бол Монгол Улсын бүртгэлийн болон Зөрчлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих талаар хууль тогтоомжид заасан төрийн захиргааны хяналт, шалгалтын талаарх бүрэн эрхийг эдэлж, хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтан мөн. Улсын байцаагчийн шийдвэрийг иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй. Улсын байцаагч хяналт шалгалт хийх объектод саадгүй нэвтрэн орох эрхтэй., “ Дугаар Үнэмлэхийг бусдад шилжүүлэхийг хориглоно., “Олгосон огноо: ”Ажиллах хугацаанд хүчинтэй. “УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ” гэсэн бичвэрийг “Arial-7” үсгийн фонд, хэмжээгээр бичнэ.

**Гурав.Үнэмлэхийн хавтас**

3.1.Үнэмлэх нь хамгаалалтын хавтастай байна.